

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

“Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг
тодорхойлох заавар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 20.10, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТОХИРОМЖТОЙ
ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР**

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Энэ зааврын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэнэ) даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд (цаашид “тохиромжтой этгээд” гэх)-ийг тодорхойлоход оршино.

ХОЁР. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох

2.1. Тохиромжтой этгээд гэж энэ зааврын 2 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. */Энэ хэсэгт 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дугаар 18 тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.2. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь хувь хүн бол:

2.2.1 Зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа төлбөргүй байх;

2.2.2 Аль нэг даатгалын компанийн ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалд томилогдон ажиллаагүй байх;

2.2.3. Шунахай сэдэлтэй болон банк, санхүүгийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гэмт хэрэг үйлдээгүй, хэрэв үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүйд тооцох хугацаа нь өнгөрсөн байх. */Энэ заалтад 2008 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн дугаар 173 тогтоолоор өөрчлөлт оруулсан/*

2.3. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол:

2.3.1. Түүний гүйцэтгэх удирдлага нь энэ зааврын 2.2-д заасан шаардлагыг хангасан байх;

2.3.2. Тухайн хуулийн этгээд, түүний гүйцэтгэх удирдлага, хувь нийлүүлэгч нь сүүлийн 2 жилийн дотор дампуурсан буюу бусад үндэслэлээр татан буугдсан даатгалын буюу даатгалын мэргэжлийн оролцогч компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хувь нийлүүлэгч биш байх;

2.3.3. Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, бизнесийн цар хүрээ нь тогтворжсон байх;

Бизнесийн цар хүрээ нь тогтворжсон байх гэж даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө

оруулагч нь Монгол Улсад 1 жилээс доошгүй хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой явуулсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улирал тутам санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад тогтмол тушааж байсан байх, сүүлийн 2 улирлын санхүүгийн тайлан тэнцэл нь алдагдалтай гараагүй байхыг ойлгоно. /Энэ хэсгийг Хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн дугаар 213 тогтоолоор нэмсэн/

2.3.4. Бизнесийн болон ёс зүйн нэр хүнд нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх буюу удирдахад харшлахгүй байх;

2.3.5. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон даатгалын компанийн нэртэй ижил нэр, логог ашиглахгүй байх.

2.4. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч нь гадаадын иргэн, хуулийн этгээд бол:

2.4.1. Энэ журмын 2.2 болон 2.3, 2.5 дахь хэсэг нэгэн адил хамаарна;

2.4.2. Тохиромжтой этгээд болохоо тодорхойлоход шаардлагатай, өөрийн харьяалах улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолт, шаардлагатай бусад материалыг гаргаж өгөх үүрэгтэй;

2.4.3. Хороо нь энэ асуудлаар бүрэн эрхийнхээ дагуу шалгах, нэмэлт материал, лавлагаа шаардах эрхтэй.

2.5. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага нь:

2.5.1. Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, даатгалын салбарт ажилласан туршлагатай байх;

2.5.2. Даатгалын чиглэлээр сургалтад хамрагдаж, ажиллах чиглэлээрээ тодорхой мэдлэгтэй, дадлага туршлагатай болсон байх;

2.5.3. Энэ зааврын 2.2 дахь хэсэг нэгэн адил хамаарна. /Энэ хэсгийг 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дугаар 18 тогтоолоор нэмсэн/

ГУРАВ. Бусад

3.1. Тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангаагүй тохиолдолд Хороо нь ердийн даатгалын болон мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

--ooOoo--